

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Аврагчийн Үйлчлэх дуудлага

Тооны хичээл үзэж байсан хүн бүр ерөнхий хэмжүүр гэж юу болохыг мэддэг. Хожмын Үеийн Гэгээнтнүүд биднийг нэгтгэдэг нэгэн зүйл байдаг. Тэр нь дэлхий дээрх Бурханы хаант улсад бидний хүлээж авсан дуудлага маань юм.

Дуудлага хүлээж аваад гомдоллож байсан тохиолдол танд байгаа юу? Эсвэл та Тэнгэрлэг Эцэг Өөрийн дуудсан хүмүүсээ адислах болно гэдгийг мэддэг учраас ах эгч нартаа үйлчлэх боломж бүртээ талархалтай байдаг уу?

Бид үйлчлэх агуу боломжуудынхаа жинхэнэ зорилгоос хазайхгүй байгаасай хэмээн би найддаг. Тэр зорилго, тэрхүү мөнхийн зорилго бол Агуу Үнэт Сувдад бичигдсэн Их Эзэний хэлсэн үгтэй утга нэг юм. “Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө.”¹

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнчлэлийн нөмрөг нь тайвшруулах нөмрөг биш харин үүрэг хариуцлагын нөмрөг юм гэдгийг бид үргэлж санаж байх болтугай. Өөрсдийгөө аврахаас гадна бусдыг Бурханы селестиал хаант улс руу удирдан чиглүүлэх нь бидний үүрэг билээ.

Бурханд үйлчлэх замаар хүсэл эрмэлзэлтэйгээр алхаснаар бид Шекспирын зохиолд гардаг Кардинал

Волсигийн орсон байдалд хэзээ ч орохгүй. Насаараа хаандаа үйлчилсэнийхээ эцэст тэрээр эрх мэдлээ алдаж, харамсан ийн халагладаг билээ:

*Ганицхан Бурхандаа л зүрх сэтгэлээ зориулан
үйлчилсэн ч болоосой*

*Би хаандаа үйлчилсэн. Тэр миний насны хүн
биш байлаа*

*Намайг дайснаудад минь хамгаалалтгүйгээр
тавьж өглөө хэмээн уйлсан гэдэг.*²

Тэнгэр биднээс ямар үйлчлэлийг шаарддаг вэ? “Их Эзэн зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг шаарддаг билээ; мөн эрмэлзэгчид хийгээд дуулгавартнууд эдгээр эцсийн өдрүүдэд Сионы нутгийн сайн сайхныг зооглох болно.”³

Ерөнхийлөгч Жонн Тейлорын хэлсэн дараах үгс надад нэгийг бодууддаг: “Та дуудлагаа сайн хийхгүй аваас Бурхан тантай дуудлагаа хийснээр аврах байсан тэр хүмүүсийн чинь төлөө хариуцлага тооцох болно.”⁴

Хүмүүсийн дунд тохинуулж байсан Есүсийн амьдрал бол яг сайн сайхны гэрэлт баганатай адил байсан. Тахир дутуу хүмүүст хүч чадал, хараагүйд мэлмий, дүлийд сонсгол хайрлаж, үхсэн хүнийг амилуулахдаа Есүс “би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг”⁵ хэмээн тунхагласан.

Сайн Самари хүний тухай сургаалт үгээрээ Эзэн бидэнд хөршөө өөрийн адилаар хайрлахыг заасан юм.⁶ Залуухан бас баян удирдагчийн тавьсан асуултанд хариулахдаа Тэрээр бидэнд хувиа хичээх байдлаас ангижрахыг заасан.⁷ 5000 хүнийг хооллохдоо Тэр бидэнд бусдын хэрэгцээг харж сурахыг заасан.⁸ Уулан дээрх Номлолоороо Тэр бидэнд эхлээд Бурханы хаант улсыг эрэлхийлэхийг заасан.⁹

“Миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно; учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно” хэмээн Их Эзэн дахин амилсныхаа дараа Шинэ Дэлхийд тунхагласан.¹⁰

Бид “сайныг үйлдэж явсан . . . Назарын Есүсийн” адил бусдад үйлчилснээр тэдний амьдралыг адисалдаг.¹¹ Тэнгэр дэх Эцэгтээ үйлчилсэнээр эдлэх баяр баяслыг авах боломжоор Бурхан биднийг адислах болно.

ЭШЛЭЛ

1. Мосе 1:39.
2. Виллям Шекспир, *King Henry the Eighth*, 3-р бүлэг, 2-р үзэгдэл, бадаг 456–58.
3. Сургаал ба Гэрээ 64:34.
4. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: John Taylor* (2001), 164.
5. Лук 22:27.
6. Лук 10:30–37; Матай 22:39-г үзнэ үү.
7. Матай 19:16–24; Марк 10:17–25; Лук 18:18–25-г үзнэ үү.
8. Матай 14:15–21; Марк 6:31–44; Лук 9:10–17; Иохан 6:5–13.
9. (Матай 6:33-г үзнэ үү).
10. 3 Нифай 27:21.
11. Үйлс 10:38.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

“Бид өөрсдийн хийх ёстой зүйлсээ хийвэл [Их Эзэн] биднийг бүтэлгүйтүүлэхгүй. Харин Тэрээр биднийг авьяас, чадвараас маань ч илүүтэйгээр өнгөлөх болно. . . . Энэ бол хүмүүний хуримтлуулж болох хамгийн сайхан туршлагаудын нэг юм” (Эзра Тафт Бенсон, *Teaching, No Greater Call* [1999], 20). Таныг эсвэл таны таних хэн нэгнийг Их Эзэн авьяас, чадвараас нь илүүтэйгээр өнгөлсөн туршлагаас хуваалцаж болно. “Аврагчийн үйлчлэх дуудлагыг” хүлээж авсан эерэг туршлагаасаа хуваалцахыг гэр бүлийнхнээсээ асуу.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Ариун сүмд үйлчлэх нь

Бенжамин А.

Б и 17 нас хүрээд ирээдүйнхээ талаар нухацтайгаар бодож эхэлсэн. Тэгээд би Тэнгэрлэг Эцэгтээ хандан номлолд явах болон мелкизедек санваар авахын тулд хэрхэн бэлтгэж болох талаар залбирсан юм. Ариун сүм бол Их Эзэний өргөө мөн тэнд Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү ойр мэт мэдрэх учраас ойр ойрхон ариун сүмд орох ёстой гэдгээ би мэдэрсэн.

Би жилд 1000 баптисм хийх зорилт өөртөө тавьсан. Энэ бол миний тавих ёстой зорилт гэж би үнэхээр мэдэрсэн бөгөөд энэ нь миний хийх ёстой зүйл мөн эсэхийг мэдэхээр мацаг барьсан юм. Тэнгэрлэг Эцэг маань надад хариулж, би бямба гараг бүр Тампико Мексико ариун сүм рүү явж эхэлсэн.

500 баптисм хийснийхээ дараа би өвөг дээдсээ олохын тулд гэр бүлийн түүхээ судлах зорилт тавьсан. Би үүнийг хийх үнэхээр дуртай болсон тул тэдний нэрсийг хайгаад унтаж ч чаддаггүй байв. Би өвөг дээдсийнхээ найман үеийн 50 нэрийг олсон бөгөөд тэдэнд зориулж ариун сүмийн ажил хийхэд тусалсан.

Би нийтдээ 1300 гаруй баптисм хийж, семинараа дүүргэж мөн мелкизедек санваар хүртсэн бөгөөд одоо амьдралын маань хамгийн чухал зорилго болсон бүрэн цагийн номлолдоо үйлчилж байна.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Би бусдын төлөө ямар нэгэн зүйл хийж чадна

Б ид бусдад туслахын тулд ямар нэгэн зүйл хийж чадна. Ерөнхийлөгч Монсон бидэнд бүх хүмүүсийг хайрлаж тэдэнд яаж тусалж чадах вэ гэдгээ харж сурах хэрэгтэй хэмээн заасан.

Гэр бүлээрээ оройн хоолоо идэхдээ тухайн өдөр ямар үйлчлэл хийсэн талаараа хуваалцахыг гэр бүлийнхээ гишүүдээс асуу. Үйлчлэлийн тухай туршлагаасаа өдөр бүр тэмдэглэлийн дэвтэртээ бич.



Итгэл, Гэр бүл, Халамж

Хэрэгтэй үед туслах нь

Энэ материалыг судлаад, гэрээр нь очиж заадаг эгч нартайгаа энэ талаар харилцан ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлж, Нийгмийн Халамжийн бүлгийг амьдралынхаа идэвхтэй хэсэг болгоход туслах асуултуудыг асуу.

Айлчлагч багшийн хувьд гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэхэд туслах нь бидний зорилгуудын нэг юм. “Надад ямар нэг зүйл тохиолдвол манай айлчлагч багш нар намайг асуугаагүй байсан ч надад туслах болно” гэж бидний зочилдог эгч нар маань мэдэрдэг байх ёстой. Үйлчлэхийн тулд бид тэдний хэрэгцээнд анхааралтайгаар ханддаг байх үүрэгтэй. Бид илчлэлт хүлээн авахаар эрэлхийлвэл өөрсдийн зочилдог эгч бүрийнхээ сүнсэлг болон материаллаг хэрэгцээнд хэрхэн туслахаа мэдэх болно. Тэгээд бид өвчин зовлон, үхэл хагацал, хүнд хэцүү үед нь өөрсдийн цаг зав, авьяас, чадвар, итгэлийн залбирал, сүнсэлг болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэн үйлчилж чадна.¹

Айлчлагч багш нарын тайлангийн тусламжтайгаар Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл биеийн болон сэтгэл санааны өвчин зовлон, үхэл хагацал, төрөлт, тахир дутуу, ганцаардал эсвэл аливаа бусад сорилт бэрхшээлийн улмаас хэнд ямар хэрэгцээ байгааг тогтоодог. Үүний дараа Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхийлөгч энэ тухай тайлангаа бишоптоо илтгэдэг. Бишопынхоо чиглүүлэл дор тэрээр тусламжийн

ажлыг зохион байгуулна.²

Айлчлагч багш нарын хувьд бидэнд “баясаж болох . . . агуу шалтгаан байна” учир нь “энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд Бурханы мутар дахь зэмсгүүд болгогдсон нь бидний дээр бэлэглэгдсэн адислал болой” (Алма 26:1, 3).

Судруудаас

Матай 22:37–40; Лук 10:29–37; Алма 26:1–4; Сургаал ба Гэрээ 82:18–19

Бидний түүхээс

Байгуулагдаад удаагүй байх үедээ сүм цөөхөн гишүүнтэй бас нэг газар төвлөрсөн байлаа. Хэн нэгэнд тусламж хэрэгтэй болоход гишүүд тэр даруй тусалдаг байсан. Харин одоо бид дэлхий даяар тарсан 14 сая гаруй гишүүнтэй. Айлчлагч багш бол Өөрийн хүүхдүүддээ туслах Их Эзэний төлөвлөгөөний нэг хэсэг юм.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх ерөнхийлөгч Хенри Б.Айринг хэлэхдээ: “Дэлхий даяар тарсан энэ том Сүмд тусламж, тайвшралыг хүртээх ганц арга зам бол хэрэгцээтэй хүмүүст ойр байдаг Бурханы үйлчлэгч нараар дамжуулан ажиллах юм.

. . . Бишоп, салбарын ерөнхийлөгч бүрт найдаж болох

Нийгмийн Халамжийн ерөнхийлөгч нь байдаг. Нийгмийн Халамжийн ерөнхийлөгч нарт эгч нэг бүрийн хүндрэл бэрхшээл, хэрэгцээг мэддэг айлчлагч багш нар нь байдаг. Тэрээр багш нараараа дамжуулан хувь хүмүүс болон гэр бүлүүдийн зүрх сэтгэлийг мэддэг. Тэр бусдын хэрэгцээнд тохируулан тусалж чаддаг бөгөөд хувь хүмүүс болон гэр бүлүүдийг тэтгэх бишопын дуудлагат ажилд тусалдаг” хэмээн хэлсэн.³

Эшлэл

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 9.5.1; 9.6.2.-ыг үзнэ үү.
2. *Гарын авлага 2*, 9.6.2.-ийг үзнэ үү.
3. Хенри Б.Айринг *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 110.

Би юу хийж чадах вэ?

1. Бусдыг адислахын тулд би өөрийн авьяас, чадвараа ашиглаж байна уу?
2. Хэрэгтэй үед нь тэдэнд туслах хүсэлтэй гэдгийг маань айлчилж очдог эгч нар маань мэдэх үү?

Нэмэлт мэдээллийг reliefsocietylds.org-аас үзнэ үү.

© 2012 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/11. Орчуулгын зөвшөөрөл: 6/11. *Visiting Teaching Message, August 2012.* -ийн орчуулга. Mongolian. 10368 363